



Санхүүгийн дэмжлэг хүссэн өргөдөл бөглөх заавар 2018-2019

Ерөнхий мэдээлэл

Болгар дахь Америкийн Их Сургуульд (БАИС) элсэн орох нь ихэвчлэн сурагчдын [академик чанарын](#) үзүүлэлтэн дээр тулгуурладаг.

Болгар дахь Америкийн Их Сургууль нь хувийн болон корпорацийн доноруудын өглөгийн ачаар бий болсон санхүүгийн тэтгэлгийг маш олон сурагчдад санал болгодог. Тэтгэлгүүд нь бүтэн эсхүл хагас байж болно, мөн доноруудын онцгойлсон нөхцөл байдалаас хамаарч олгодог. Зарим донор нь сургалтын амжилтыг дэмжин тэтгэлэг олгодог бол зарим нь санхүүгийн хэрэгцээнд үндэслэн олгодог.

БАИС сурагчдын академик амжилт болон санхүүгийн хэрэгцээн дээр нь үндэслэн тэтгэлэг олгодог. Санхүүгийн хэрэгцээт байдлыг БАИС-аас Санхүүгийн Дэмжлэг Хүссэн Өргөдөл болон өргөдөлтэй хамт ирсэн нэмэлт материалууд дээр үндэслэн тогтоодог болно.

Санхүүгийн дэмжлэг нь сургалтын төлбөрийн нэг хэсгийг төлдөг бөгөөд буцаан төлөгдөх албагүй. Санхүүгийн дэмжлэг нь хамгийн дээд талдаа суралцах хугацааны найман семестерт хүчинтэй байдаг ба сайн дүнтэй байх нөхцөлтэй байдаг.

БАИС нь Хувийн Мэдээллийг Хамгаалах Хуулийг даган мөрддөг. Хувь хүний мэдээллүүдийг найдвартай нууцалдаг бөгөөд зөвхөн Санхүүгийн Дэмжлэгийн Комисс элсэн орж буй сурагчид өгөх тэтгэлгийн хэмжээг тогтоох зорилгоор л хэрэглэдэг болно. Санхүүгийн Дэмжлэгийн Өргөдөлийн хамт бүрдүүлсэн нэмэлт материалууд (бичиг баримтууд) нь БАИС-ын эрх мэдэлд бүрэн очдог ба буцаан олгогдохгүй болно.

БАИС нь энэхүү маягт болон хамт байгаа бүх мэдээллүүдийн үнэн зөв эсэхийг шалгах эрхийг хадгалдаг. Санхүүгийн Дэмжлэг Хүссэн Өргөдөлд хуурамч болон төөрөгдүүлсэн мэдээлэл оруулснаар таньд олгогдсон бүх тэтгэлгийг цуцлахад хүргэх бөгөөд БАИС-д дахин элсэн орох хүсэлт гаргах эрхгүйгээр сургуулиас хасахад хүргэнэ. Санхүүгийн Дэмжлэгийн Өргөдөлд буй мэдээлэл болон нэмэлт материалууд нь сайн дураараа өгөгдсөн байна.

Болгар дахь Америкийн Их Сургууль нь ялгаварлан гадуурхалын эсрэг мөн тэгш эрхийн зарчмыг даган мөрддөг бөгөөд ажилчид болон сурагчидын зөвлөл хоёулаа даяарших үүрэгтэй байх нь зөв гэж үзэцгээдэг.

Заавар:

Хэрэв Та БАИС-иас санхүүгийн дэмжлэг болон тэтгэлэг авах хүсэлтэй байгаа бол тус Санхүүгийн Дэмжлэгийн Өргөдөл (СДӨ) нь БАИС-д элсэн орох багц материалын салшгүй нэгэн хэсэг юм. Дэмжлэг авахыг хүсэж байгаа бол энэхүү маягыг бүрэн бөглөхийг таниас хүсч байна. СДӨ-г бүрэн бөглөөгүй болон нэмэлт материалаа бүрэн илгээгээгүй тохиолдолд санхүүгийн туслалцаа авах боломжгүй. Хэрвээ та СДӨ-ийг өгөөгүй бол таньд ямар ч төрлийн санхүүгийн дэмжлэг өгөх боломжгүй бөгөөд сургуульд элсэн орсоны дараах эхний хоёр семестерт санхүүгийн дэмжлэг болон тэтгэлэгт хамрагдах боломжгүй. Сургууль нь санхүүгийн туслалцаа хэрэгтэй байгаа бүх оюутануудад тэтгэлэг олгох боломжгүй. Учир нь тэтгэлэгийг тогтоохдоо өргөдөл мэдүүлэгчийн болон гэр бүлийнхний зүгээс өгсөн хувийн нууц мэдээлэл дээр үндэслэдэг ба тэтгэлэгийн шийдвэрийн тухай өргөдөл мэдүүлэгч болгонд нарийвчлан тайлбарлах боломжгүй.

Хэрэв дагалдах материалууд нь байхгүй бол, маягыг нь бүрэн биш гэж тооцно. Хэрвээ та ямар нэгэн баримт оруулах шаардлагагүй эсхүл тэрхүү зүйл нь хамааралгүй бол N/A (хамааралгүй) гэж бөглөнө. Та өргөдөлд гарын үсэг зурсанаар материалууд дээр үндэслэн өөрийнхөө хүсэлтийг харж үзэхийг хүсч байна гэсэн үг юм. Та дараа нь нэмэлт материал оруулах боломжгүй болно.

Хэрвээ та өргөдлийн ямар хэсгийг нь бөглөж чадахгүй эсвэл шаардлагатай бичиг баримтны аль нэгийг нь явуулах боломжгүй бол 53-р эгнээн дээр тайлбараа оруулна уу. Энэхүү маягыг дутуу мэдээлэлтэй явуулбал санхүүгийн дэмжлэг эсвэл өргөдлийг тооцохгүйд хүргэнэ. Хэрвээ таньд ямар нэгэн асуух зүйл байгаа бол financialaidoffice@aubg.edu хаягаар холбоо барина уу.

Эгнээ бүрийг бөглөх заавар:

Эгнээ 1 БАИС-д элсэн орох гэж байгаа өргөдөл гаргагчийн нэрийг нь бичнэ. Овгоо ТОМООР бичиж эхлэх ба түүний араас нь өөрийнхөө нэрийг бичнэ.

Эгнээ 2 Хэрвээ өргөдөл гаргагч нь эрэгтэй бол Эрэгтэй гэсний хажуудах нүхийг чагтална, эсхүл эмэгтэй бол Эмэгтэй гэсний хажуугийн нүхийг чагтлана.

Эгнээ 3 Өргөдөл гаргагчийн төрсөн өдрийг бөглөнө, эхлээд CAP, араас нь ӨДӨР, тэгээд ОН.

Эгнээ 4 Өргөдөл гаргагч нь БАИС-ыг 2017 оны Намар эсвэл 2018 оны Хавар сурч эхлэхээ харгалзах нүхийг чагтлаж бөглөснөөр нотлох болно.

Эгнээ 5 Өргөдөл гаргагчийн харъяалагдах улсын нэрийг бичнэ.

Эгнээ 6 Өргөдөл гаргагч одоо амьдарч буй улсынхаа нэрийг бичнэ.

Эгнээ 7 Өргөдөл гаргагчийн амьдарч буй хот, аймаг эсвэл сумын нэр.

Эгнээ 8 Өргөдөл гаргагчийн төрсөн эцэг, эхийн нөхцөл байдлыг зөв тодорхойлсон нүхийг чагтлана (ганц нүхийг бөглөнө үү.)

Эгнээ 9 Өөрийнхөө гэр бүлийн гишүүдийн тоог бичнэ үү. Эцэг эх болон төрсөн ах дүүс хамаарагдах ба хойд эцэг эхтэй бол мөн адил бичнэ. Өөд болсон гэр бүлийн гишүүд хамаарагдахгүй болно.

Эгнээ 10 10а-с 10f хүртэлх эгнээнд ойрын хамаатнуудаа жагсаан бичнэ. 10а дахь мөрөн дээр хамгийн их орлоготой гэр бүлийн гишүүнийг, хоёр дахь хамгийн их орлоготой хүнээ 10b мөрөнд, мөн гурав дахь хамгийн их орлоготой хүнийг 10с дэхь мөрөнд бичнэ. “Өргөдөл гаргагчтай ямар холбоотой болох” гэх баганад гэр бүлийн ямар холбоотой болохоо бичнэ (эцэг, эх, эгч гэх мэт.). “Нас” гэх баганад тухайн хүний насыг нь бичнэ. Хэрвээ өөр ямар нэгэн гэр бүлийн гишүүн байгаа бол нэмэлт хуудсан дээр оруулна.

Эгнээ 11 11а-с 11с хүртэлх мөрөнд одоогийн байдлаар ямар нэгэн сургууль эсвэл их сургуульд сурдаг гэр бүлийн гишүүдийн талаарх мэдээллийг оруулна. “Суралцах жилийн зарлага” гэсэнд сургалтын төлбөр дээр заавал төлөх шаардлагатай нэмэлт төлбөрийн хэмжээг бичнэ. “Гэр бүлийн хөрөнгө оруулалт” гэсэн хэсэгт сурагчийн төлбөрт нь гэр бүлийн зүгээс төлж барагдуулдаг хэмжээг бичнэ. “Орлого/зээл/ажил” гэсэн хэсэгт сурагчид сургуулиас нь өгдөг санхүүгийн туслалцааны хэмжээг бичнэ. Энэ хэмжээ нь “Суралцах жилийн зарлага”-аас “Гэр бүлийн хөрөнгө оруулалт”-ыг хассантай тэнцүү байх ёстой. Хэрэв дунд сургууль эсвэл их сургуульд сурдаг гэр бүлийн гишүүн байхгүй бол 11а мөрөнд N/A гэж бичнэ.

Эгнээ 12 Гэр бүлийн ерөнхий харъяаллын газрыг зөв тодорхойлсон нүхийг бөглөнө. Хэрвээ гэр бүл тань байр эзэмшдэг бол “Эзэмшдэг” гэснийг чагтлана. Хэрвээ таны гэр бүл түрээс төлөлгүй бусдын харъяалалтай газар амьдардаг бол “Бусадтай амьдардаг” гэсэн нүхийг чагтлана.

Эгнээ 13 10а мөрөнд бичигдсэн хүний (Хамгийн их орлоготой хүн) нэрийг нь бичнэ (Овог, нэр). 13а мөрөнд энэ хүний ажил мэргэжлийг бичнэ. 13b-с 13g хүртэлх эгнээнд тус хүний ажил олгогчийн бүтэн хаяг, 13h мөрөнд ажил олгогчийн утасны дугаарыг бичнэ.

Эгнээ 14 10b-д бичигдсэн хүний (Хоёр дугаар хамгийн их орлоготой хүн) нэрийг нь бичнэ (Овог, нэр). 14а мөрөнд тус хүний ажил мэргэжлийг нь бичнэ. 14b-с 14g хүртэлх эгнээнд тус хүний ажил олгогчийн бүтэн хаяг, 14h мөрөнд ажил олгогчийн утасны дугаарыг бичнэ.

Эгнээ 15 10с-д бичигдсэн хүний (хоёр дугаар хамгийн их орлоготой хүн) нэрийг нь бичнэ (Овог, нэр). 15а мөрөнд тус хүний ажил мэргэжлийг бичнэ. 15b-с 15g хүртэлх эгнээнд тус хүний ажил олгогчийн бүтэн хаяг, 15h мөрөнд ажил олгогчийн утасны дугаарыг бичнэ.

Эгнээ 16 Ажил эрхлэлттэй холбоотой нэмэлт мэдээллүүд байвал оруулна уу.

Эгнээ 17 – 22 Тус эгнээнд өргөдөл гаргагчийн эцгийн (эгнээ 17), эхийн (эгнээ 18), өргөдөл гаргагч өөрийн (эгнээ 19), өргөдөл гарагчийн хамтран амьдрагчийн (эгнээ 20), болон 10а, 10b, 10с (эгнээ 21) эгнээнд бусад хүмүүсийн нийт орлогын дүнг (татвар авахаас өмнөх нийт дүн) бичнэ. 22-р эгнээнд багана болгонд гэр

бүлийнхний нийт орлого, нийт орлогоос авсан татвар, мөн нийт цэвэр орлогын дүнг жагсаан бичнэ. Тохиолдол болгонд нийт орлогын хэмжээг үндэсний мөнгөн тэмдэгтээр бичнэ.

Эгнээ 23 – 28 Тус эгнээнд өргөдөл гаргагчийн ойрын гэр бүлийн гүшүүд бизнес эрхэлдэг бол эцэг, эх, өргөдөл гаргагч өөрөө, өргөдөл гаргагчийн хамтран амьдрагч, болон 10a, 10b, эсвэл 10c (эгнээ 21) эгнээнд бичигдсэн бусад хүмүүсийн нийт орлого, зарлага, ашиг (алдагдал) зэргийг жагсаан бичнэ. Тохиолдол болгонд хамгийн сүүлийн жилийн тоог оруулна. 28-р эгнээнд багана болгонд гэр бүлийн нийт орлого, зарлага болон ашгийн (алдагдал) тоог нэмж бичнэ. (iv) гэсэн баганад тухайн бизнест ажилладаг нийт ажиллагсдын тоог бичнэ.

Эгнээ 29 23-28-р эгнээнд бичигдсэн бизнестэй холбоотой нэмэлт мэдээллүүдийг оруулна.

Эгнээ 30-35 Тус мөрөнд өргөдөл гаргагчийн эцэгт (мөр 30), эхэд (мөр 31), өргөдөл гаргагч өөрт нь (мөр 32), өргөдөл гаргагчийн хамтран амьдрагчид (мөр 33), болон 10a, 10b, 10c-д бичигдсэн бусад хүмүүсийн (эгнээ 34) жил бүр авдаг тэтгэвэр, ажилгүйдлийн нөхөн олговор, хүүхдийн тэтгэмж, мөн нийгмийн даатгалын нөхөн олговор тус тус жагсаан бичнэ үү. 35 дахь мөрөнд нийт тэтгэмж, ажилгүйдлийн нөхөн олговор, хүүхдийн тэтгэмж болон нийгмийн даатгалын нөхөн олговрын нийт дүнг бичнэ.

Эгнээ 36 Энд 22 (цэвэр ашиг) дахь мөрний гурав дахь баганы нийт дүн, 28 дахь (орлого) мөрний гуравдугаар багана, мөн 35 дахь бичигдсэн гэр бүлийн нийт орлогыг гаргаж авахын тулд нэмнэ тэгээд нийт дүнг нь 36 дахь мөр дээр бичнэ.

Эгнээ 37-42 Эдгээр мөрөнд өргөдөл гаргагчийн эцэг (мөр 37), эх (мөр 38), өргөдөл гаргагч өөрөө (мөр 39), өргөдөл гаргагчийн хамтран амьдрагч (мөр 40), болон 10a, 10b, 10c-д бичигдсэн бусад хүмүүсийн (мөр 41) нэр дээр байгаа банкны дансан дахь мөнгөний хэмжээг жагсаан бичнэ. 42 дахь мөрөн дээрх 37-41 мөрнүүд дэх дүнг нэмэн гэр бүлийн нийт хадгаламжийн дүнг гаргаж авна.

Эгнээ 43 Хэрэв өргөдөл гаргагчийн гэр бүлийн хэн нэг гишүүн байшин, орон сууц, газар эзэмшдэг бол дараах мэдээлэл өгнө үү: (i) эзэмшигчийн нэр; (ii) байшин, орон сууц газрын тодорхойлолт; (iii) байшин, орон сууц, газрын хаяг. Тус бүрийг 43a, 43b, 43c мөрнүүдэд жагсаан бичнэ. Шаардлагатай бол нэмэлт хуудас хавсаргаж болно.

Эгнээ 44 Гэр бүлийн хэн нэгэн гишүүний эзэмшдэг автомашины мэдээллийг өгнө үү: (i) үйлдвэрлэгчийн нэр (брэнд); (ii) загварын нэр; (iii) үйлдвэрлэсэн огноо; (iv) лицензийн дугаар.

Эгнээ 45 Өргөдөл гаргагчийн олон улсын аялалын тухай мэдээлэл. Аялал бүрт (i) аялсан улс; (ii) аялалын зорилго (бизнес, аялал жуулчлал гэх мэт); (iii) аялалын огноо (сар/он).

Эгнээ 46 Өргөдөл гаргагчийн гэр бүлийн зүгээс дараагийн хичээлийн жилд санхүүгийн тусламж үзүүлэх боломжит төсөв тооцоо. Энэ хэмжээг Америк доллараар илэрхийлнэ үү.

Эгнээ 47 БАИС-иас гадуурх эх сурвалжаас (хэрэв байгаа бол) авч буй тэтгэлэгийн мөнгөн дүнг Америк доллараар илэрхийлнэ үү.

Эгнээ 48 Ирэх хичээлийн жилд өргөдөл гаргагчийн хамаатан садан болон найз нөхдийн зүгээс үзүүлэх санхүүгийн тусламжийн мөнгөн дүнг ам. доллараар илэрхийлэн бичнэ үү.

Эгнээ 49 Ирэх хичээлийн жилд хувийн спонсорын (хэрэв байгаа бол) зүгээс үзүүлэх санхүүгийн тусламжийн мөнгөн дүнг ам. доллараар илэрхийлэн бичнэ үү.

Эгнээ 50 Өргөдөл гаргагч зун ажил хийгээд ирэх хичээлийн жилийн төлбөрт зарцуулах мөнгөн дүнг ам. доллараар илэрхийлэн бичнэ үү.

Эгнээ 51 46-50 эгнээнд дээр дурьдагдсанаас өөр ямар нэгэн орлогын эх сурвалжаас ирэх хичээлийн жилд санхүүгийн тусламж авах бол мөнгөн дүнг ам. доллараар илэрхийлэн бичнэ үү.

Эгнээ 52 46-51 мөрөнд жагсаагдсан мөнгөн дүнг нэмээд нийт дүнг гаргана.

Эгнээ 53 Энэ зайн дээр дурьдагдсан хандив тусламжуудын тухай ямар нэгэн тайлбар бичихэд ашиглана уу. Мөн таньд шаардлагатай хандивын мөнгөн дүнг тодорхойлоход бид анхаарч үзэх хэрэгтэй гэж бодож буй тусгай нөхцөл байдлуудыг дурьдана уу. Зээл барьцаа, түрээстэй холбоотой баримтуудыг мөн багтааж болно. Шаардлагатай бол нэмэлт хуудас хавсаргаж болно.

Эгнээ 54 Өргөдлийн маягт бүрэн өгөхийн тулд доорх шаардлагатай баримтуудыг бүрдүүлж өгнө. СДӨ-д багтаж буй баримтууд нь эх хувь эсхүл баталгаат хуулбарууд байх ёстой. Бүх батламж болон баримтууд нь ойрын 12 сарын дотор байх бөгөөд Болгар хэл дээр л биш бол материалиуд бүгд англи хэл дээр орчуулагдсан (албан ёсны орчуулгын товчоо) байх ёстой. Хэрэв аль нэг шаардлага таньд хамааралгүй бол N/A гэж бичнэ (жишээлбэл, хэрэв эцэгт тань ажилгүйдлийн нөхөн олговор олгогддоггүй бол 54e мөрөн дээр N/A гэж бичнэ.)

Шаардлагатай бичиг баримтууд:

A. Тухайн гэр бүлд ажил хийдэг гишүүд болгоны цалингийн сарын болон жилийн орлогын мэдүүлэг (тухайн ажиллаж байгаа албан газраасаа авна)

B. Өнгөрсөн жилийн орлогын албан татварын (хувийн бизнес, үйл ажиллагаа, хувийн болон улсын байгууллагад эзэмшдэг хувьцаа, эдлэн газрын түрээсийн мөнгө, бусад нэмэлт орлого) мэдүүлэгийн хуулбарууд (гэр бүлийн ажиллаж буй бүх гишүүдэд хамааралтай)

C. Хэрвээ танай эцэг эх ямар нэгэн худалдаа үйлвэрлэл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхэлдэггүй бол эцэг эхийн аль аль нь хоёулаа Дүүргийнхээ Татварын Газраас "аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхэлдэггүй бөгөөд татварын өр тооцоогүй" гэсэн тодорхойлолт авах хэрэгтэй.

Мөн үүнтэй хавсарган эцэг эх тус тусдаа худалдааны үйл ажиллагаанд оролцдоггүй бөгөөд тодорхойлолт/мэдүүлэгт дурьдсанаас гадуур аливаа шууд болон шууд бус

хэлбэрээр ашиг олдоггүй ба үл хөдлөх хөрөнгөгүй гэсэн нотариатаар батлуулсан баримт үзүүлэх хэрэгтэй. Хэрэв өргөдөл гаргагчийн эцэг эх тодорхойлолтын шаардлагыг зөрчвөл хуулийн хариуцлага хүлээнэ гэдгийг мэдэж байгааг илэрхийлсэн байх ёстой.

D. Өргөдөл гаргагч болон гэр бүлийн гишүүдийн нэр дээр байдаг хадгаламжийн дансны мэдээлэлийг харъяа банкнаасаа авах.

E. Гэр бүлд ажилгүй гишүүд байгаа бол Хөдөлмөр Нийгмийн Халамжийн Газраас "Ажилгүй" гэсэн тодорхойлолт авна. Мөн ажилгүйдлийн тэтгэмж авдаг бол хэдийг авдагийг дурьдсан байх.

F. Хэрвээ гэр бүлд тэтгэвэрийн насны хүн байгаа бол тэтгэвэрийн орлогын тодорхойлолт

G. Гэрлэлтээ цуцлуулсан эцэг эхийн хувьд шүүхийн шийдвэрийн хуулбар хэрэгтэй. Мөн одоогоор эцэг эх нь дахин гэрлэсэн эсхүл ганц бие байгаа эсэх талаар тодорхойлолтыг холбогдох газраас авах

H. Хүүхдийн тэтгэмжийн баримт (хэрэв байгаа бол).

I. Хэрвээ эцэг эх нь нас барсан бол нас барсны гэрчилгээний хуулбар. Мөн одоогийн байдлаар эцэг, эхийн гэр бүлийн байдлыг харуулсан тодорхойлолтыг холбогдох газраас авах

J. Гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл мэндийн асуудалтай бол түүнийг тодорхойлсон эмнэлэгийн бичиг

K. Гэр бүлийн гишүүд ямар нэгэн тээврийн хэрэгсэл эзэмшдэг бол түүний гэрчилгээ, мөн хувиараа аж ахуй эрхэлдэг бол түүний бүртгэлийн гэрчилгээ

L. Гэр бүлийн гишүүдийн нэр дээр байдаг байр, газар болон бүх үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ

Эдгээр бүх бичиг баримтуудыг:

- *Хувилуулаад*
- *Хувилснаа нотариатаар батлуулаад*
- *Орчуулагын товчоогоор орчуулуулсан байх хэрэгтэй. Зөвхөн Англи хэл рүү хөврүүлсэн байх шаардлагатай. Эдгээр бүх бичиг баримтууд бүрэн байхаас гадна хэрвээ эдгээр бичиг баримтуудыг зарим нэг нь үнэхээр байхгүй тохиолдолд ар гэрийнхээ нөхцөл байдлын тухай өргөдөл бичих хэрэгтэй.*

Эгнээ 55 Өргөдөл гаргагч болон эцэг эх тодорхойлолт дээр гарын үсэг зурах ёстой. Гарын үсэг зурснаар хоёр тал дараах зүйл дээр зөвшилцөж байгааг илэрхийлнэ:

(i) Зааврыг уншиж ойлгосон.

(ii) Энэ өргөдөлд багтсан бүх мэдээлэл үнэн зөв бөгөөд бүрэн.

(iii) Санхүүгийн өргөдөлийг дутуу бөглөсөн мөн шаардсан бичиг баримт дутуу бол хүчингүйд тооцогдоно.

(iv) Энэхүү өргөдөлийг явуулсанаар нэмэлт мэдээлэл оруулах эсхүл тухайн жилдээ дахин өргөдөл мэдүүлэх боломжгүй.